



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 21 өдөр

Дугаар

A/67

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.9.10 дахь заалтыг тус тус үндэслэн, Эрчим хүчний яамны 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.
2. Энэ тушаалын хавсралтаар батлагдсан ажлын төлөвлөгөөний биелэлтийг хагас болон бүтэн жилээр гаргаж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Т.Ариунбаатар)-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.МӨНХӨӨ



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН 2025 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур	Хугацаа	Хариуцах эзэн
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх 1.2. Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүтэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах;	-Баримтжуулсан байх -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) -Харьяа нэгжүүдийг хамруулсан байх. -АТГ-ын авлигын мэдээлэл хүлээн авах дугаарыг төрөл бүрийн хэлбэрээр сурталчлан ажилласан байх; -Тайланд 110 дугаарыг сурталчилсан баримт бүрийн нотломжийг хавсаргасан байх.	5	Хуулийн мэргэжилтэн, Мэдээллийн технологи, программ хангамж хариуцсан инженер

1	2	3	4	5	6
2	Ил тод байдал, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, Шинээр томилогдсон эрх бүхий албан тушаалтнуудад Авлигын эсрэг хууль, тогтоомжийг танилцуулах,	2.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл /Үнэлгээний хороо, Гэрээ байгуулах гм/-ийг шилэн дансанд оруулсан тоон мэдээлэл	Баримт, нотломжийг хавсаргасан байх.	Жилдээ	Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга, Хуулийн мэргэжилтэн
		2.2. Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших;			
		2.3. Шинээр томилогдох албан тушаалтнуудад холбогдох хуулийн танилцуулга танилцуулах	Шинэ томилогдсон эрх бүхий албан тушаалтнуудад авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гарын авлага танилцуулах.		Хуулийн мэргэжилтэн, Сургалт, судалгааны мэргэжилтэн, Захирлын туслах
3	Соён гэгээрүүлэх, мэдлэг олгох	3.1. Эрчим хүчний салбарын алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг арилгахад чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;	Сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байх;	Жилдээ	Хуулийн мэргэжилтэн, Сургалт, судалгааны мэргэжилтэн,